



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 5/160

Хэрлэн сум

Д.Наранцацралыг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, 43.3.4 дэх заалт, Засгийн газрын “Журам батлах тухай” 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 489 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан ажлын зайлшгүй шаардлагаар төрийн албаны нөөцөд бүртгэлтэй Дашдондогийн Наранцацралыг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Д.Наранцацралын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий Нягтлан бодогч
	Х.Баярбаатар	Төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн
	Д.Энхтуяа	Архив, Бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

3. Д.Наранцацралын цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоож, үндсэн цалинг 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянган) төгрөгөөр, төрийн алба хаасан

2.

хугацааны нэмэгдлийг 17 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д үүрэг болгосугай.

4.Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Наранцацралд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА